

МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРОН ЦАГИЙН НЭР ХОРШИХ НЬ

Ч. Бямбаханд¹

Хүн төрөлхтөн хэл хэрхэн үүсч бий болсон талаар эрт дээр үеэс сонирхон, хялбар нээх боломжгүй хэлний нарийн үзэгдлүүдийн гогцоо ээдрээг алхам алхмаар нээсээр байна.

Орчлон ертөнцийн юмс үзэгдлийн оршин байх хэлбэрүүд нь орон зай, цаг хугацааны шүтэлцээ болон хөдөлгөөн юм. Юм үзэгдлийг хүртэн мэдрэх үйл явц гурван хэмжүүрт орон зай, нэг хэмжүүрт цаг хугацаанд болох бөгөөд эхлээд хөдөлгөөний байрлал, дараа нь ерөнхий төрх байдлыг дүгнэх, улмаар дотоод нарийн эд ангийн ерөнхий хэлбэрээр хүртэн мэдрэх замаар явагдана. Хүн хэлийг анхлан сурахдаа хэл зүйн нарийн үзэгдлийг шууд ялган таньж мэддэггүй шиг хэл ярианд орон цагийн хэмжигдэхүүний баримжаа ойлголт ч танин мэдэхүйн явцтай холбогдон хэлэнд янз бүрээр илэрнэ.

Тийм учраас хэлний хэлбэрийн талаас орон цагийн нэр хоршиж, хоёр үг зэрэгцэн нэг ухагдахууныг илэрхийлж байгаа нь үгийн утга өргөсөх, хоорондын харьцааг судалхад төдийгүй агуулгын талаас хүн төрөлхтний сэтгэхүй дэх орон цагийн ойлголт монгол хэлнээ (дан буюу) хоршсон нэгжээр хэрхэн илэрч буйг авч үзэхэд сонирхолтой юм.

Монгол хэлний хоршоо үг нь онол хэрэглээний түвшинд шавхагдашгүй арвин судлагдахуунтай тул олон эрдэмтэн судлаачид шинжлэн судалсаар байна. Тухайлбал, Академич Ш. Лувсанвандан, Б. Дэмчигдорж нар "...хоёр өөр үндэс бүхий үгсийг хоршиж өгүүлбэр зүйд үг бүтээх ёс бий бөгөөд нэгэн хийсвэр ухагдахууныг илтгэж чадах тул уул үгсийг дан дангаараа байснаас өөр шинэ үг буюу хоршоо үг бүтээдэг" гээд 1. эсрэг тэсрэг утгатай 2. утга ойролцоо 3. утга тус тус өөр 4. эхнийх нь эгшиг бол ~м, с~м, ш, т, з-ээр солих 5. мөхсөн язгуурт -в залгаж давтан дуудах 6. нэрийг "үгүй" гэх үгтэй хоршсон 7. нэрийг давтан хорших 8. холбогдол бүхий үгийг давтаж 9. үйл үгийг давтан хорших зэргээр хоршоо үг бүтнэ гээд² дараагийн судалгаандаа нийлмэл үгийг хоршоо үгээс ялгажээ. Тэрээр дайвар үгийг хэлзүйн талаас судалж, дутмаг нэр гэж нэрлэж улмаар 1968 онд "Орчин цагийн монгол хэлний бүтэц" гэх бүтээлдээ орон цагийн нэр гэж үзсэн.

Харин академич Б. Ринчен "үг хорших ёс, хоршин хүртэх ёсыг нарийвчлан судалж, эл хоршоо үг бүтэхийн ёсонд нэр үг нэр үг лүгээ нийлэн хоршоо үг болох нэгэн зүйл бий. Түүнээ нэрийтгэл нэр, нэрийтгэл нэр лүгээ хорших нэгэн зүйл; цагт нэр цагт

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

² Лувсанвандан Ш. Дэмчигдорж Б. Монгол хэлний зүй -I, Уб., 1951, 50 дугаар тал

нэр лүгээ хорших нэгэн зүйл; сул нэр, сул нэр лүгээ хорших нэгэн зүйл бий³ гээд орон цагийн хоршоо үгийг сул үг хоршиход хамруулан үзжээ.

М. Базаррагчаа “Турвын тухай гурвал” зохиолоос хоршоо үгийг түүн үгсийн айгаар ялган давтамжийг гаргасан нь статистик үзүүлэлтээр орон цагийн нэр, түүний хоршсон хэлбэрийн давтамжийг гаргажээ. Үүнд: Жинхэнэ нэр-374, үйл үг-213, тэмдэг нэр- 97, тооны нэр-8, дайвар үг (дүрслэх)-2, дайвар үг-22, төлөөний үг-9, мөн жинхэнэ нэр орны утгаар орсон үг-12, үйл үг дүрслэх дайвар үгийн утгаар орсон үг-8, жинхэнэ нэр төлөөний үг хоршсон үг-17, тооны нэр тэмдэг нэр хоршсон үг-4, төлөөний үг тэмдэг нэр хоршсон үг-10, тэмдэг нэр дайвар үг хоршсон үг-3, жинхэнэ нэр тэмдэг нэр хоршсон үг-11 орсон⁴ байна гээд “Хоршоо үг нь зэрэгцсэн байдгаараа үг давтах ёстой, зүйрлэн нэрлэдгээрээ хэлц үгтэй шууд нэрлэдгээрээ нийлмэл үгтэй тус тус ижил бөгөөд, хоршоо ба хэлц үг, нийлмэл ба давтсан үг дөрөв нь тогтвортой буюу чөлөөт бус холбоо үгийн бүрэлдэхүүн хэсэг болдог гээд холбоо үгийг тогтворгүй ба тогтвортой гээд тогтвортой холбоо үгийг 1.үгийн санжсан холбоо үг (а.өвөрмөц хэлц б.хоршоо үг), 2. хэлзүйжсэн холбоо үг (а.нийлмэл үг, б.хэлзүйжсэн үг)⁵ гэж ангилсан байна.

Үүнээс үзвэл орон цагийн ойлголт нь монгол хэлнээ хэл зүйн талаас бусад үгсийн айгаар илэрхээс гадна бас орон цагийн нэр дан ба хоршсон хэлбэрээр, мөн бусад үгсийн аймагтай хоршин илэрч, хам хийсвэр утга илэрхийлэх хэрэглээний давтамж нэлээд арвин байдаг байна. Тухайлбал: 1.орон цагийн нэр-орон цагийн нэртэй хорших: эрт орой, урьд хожид, ашид мөнх, хожим хойно, дээр доор, хойно урд, баруун зүүн, гадна дотно, гадар дотор гэхэд орон цагийн нэр нь харилцан зэрэгцсэн харилцаанд байна. Орон цагийн нэр хоршин хийсвэр утга илэрхийлэх ч эхийн утгаас хамаарч утга шилжих нь бий. Жишээ нь: өөд уруугүй, наана цаанагүй, наашаа ч үгүй цаашаа ч үгүй, наана цааныг бодохгүй гэх мэт. 2. орон цагийн нэр- утга шилжсэн үгтэй хорших: уруу үхээнц, уруу дорой 3. орон цагийн нэр- бусад үгсийн аймагтай хорших 4. орон цагийн нэр- орон цагийн утгат үгтэй хорших, 5. орон цагийн утгат үгс хорших: (бусад үгсийн аймагтай хоршин орон цагийн утга илэрхийлнэ) хавар намар, өвөл зун, хавар зун, зун намар, газар тэнгэр, үүсгэл төгсгөл, эх адаг, тэнгэр газар, орон байр, гэр орон гэх мэт.

Монгол хэлний орон цагийн нэрс нь жинхэнэ нэр, үйл үгийн адил бүтэх аргатай. Үгийн язгуур, үндсэнд -на, -р, -ш, -уур (-үүр), -аар (-ээр), -д (-т) зэрэг дагавар залгаж нийлэг аргаар, баруун хойно, зүүн урд, эрт орой, урьд хожид, эргэн тойрон, мэр сэр, аар саар, ойр орчим, өнө эрт, түр зуур, ашид мөнх, хожим хойно гэх мэтээр хоршиж, хавсарч задлаг аргаар тус тус бүтнэ⁶ гэж монгол хэлний орон цагийн нэр хорших үзэгдлийг хорших буюу хавсарсан задлаг аргад хамруулан үзжээ. Гэвч энд мэр сэр, аар саар гэх үг нь орон цагийн нэрд шууд утгаараа хамаарахгүй.

Г.Д.Санжеев “Утга зүйн үүднээс авч үзвэл, хоршоо үг хоёр хэв шинжтэй.

1. бүрдүүлж буй хос үгс шинэ ухагдахуун тэмдэглээгүй, өөрийн утгаа хадгалж үүссэн нэг тохиолдол 2. хоршоо үгийг бүрдүүлж байгаа гишүүд цөм утгаа алдаж, шинэ үг бүтээдэг тохиолдол бий⁷” гэсэн нь орон цагийн нэр дээр ч ажиглагдаж байна.

Иймд орон цагийн солибцол буюу огтлолцлыг илэрхийлсэн хэлний сонирхолтой жишээ бол орон цагийн нэрийн хоршоо үг тул судлууштай үзэгдлийн нэг юм. Цаг

³ Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Уб., 1967, 1 дүгээр тал

⁴ Базаррагчаа М. Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд. Уб., 1990, 24 дүгээр тал

⁵ Базаррагчаа М., Идэрбаяр Б. Монгол хэлний хоршоо үг. Уб., 1993, 77 дугаар тал

⁶ Өнөрбаян Ц. Орчин цагийн монгол хэлний үг зүй. Уб., 2004, 225 дугаар тал

⁷ Санжеев Г. Д. Грамматика бурят- монгольского языка. М., 1941, стр. 39

хугацаа бол скаляр хэмжигдэхүүн, хуваагддаг, тоон хэмжээстэй, чиглэлгүй, харин орон зай бол вектор хэмжигдэхүүн, хуваагддаггүй, тоон хэмжээстэй, чиглэлтэй байдаг нь хэлэнд тодорхой хэмжээгээр тусгалаа олсон байдаг. Хөдөлгөөн нь орон зай, цаг хугацааны нэгдэл болохын хувьд учир шалтгааны холбогдлыг тайлбарлах, учир шалтгааны тонгоруу байдал цаашилбал хэлний тонгорол, давтах хэлбэрийг тайлбарлах сэжиг болно. Нэг талаас орших орон, нөгөө талаас хөдлөх орон буюу орших, хөдөлгөөн хөёр, орны эзлэх зай, цагийн эзлэх хугацаа нь орон, цагийн мөн чанартай шууд холбоотой учир тэдгээрийн нэгдмэл байдал, ялгаатай талыг мөн илэрхийлдэг. Зай гэдэг бол орны эзэлж байгаа байр суурь зэрэгцэн орших байдлыг илэрхийлдэг. Хугацаа гэдэг бол цагийн үргэлжилж байгаа байдал, ийм учраас зайн талаас авч үзвэл орон нь аливаа үзэгдэл юмсын оршин байх, эзлэх байршлын дэс дараалал юм. Өөрөөр хэлбэл, нэг үзэгдэл юм нөгөөгийнхөө дэргэд оршиж байна гэсэн үг юм. Хугацааны үүднээс үзвэл цаг гэдэг бол юмс үзэгдлийн оршин байх үеийн цагийг үзүүлдэг бөгөөд энэ нь монгол хэлнээ орон цагийн нэр хорших байдлаар хэрхэн илэрдгийг авч үзье.

Орон цагийн нэр хорших нь:

А. - а. орших орон, б. хөдлөх орон (тодорхой зүгт, тодорхойгүй зүгт)

Б. - цаг (эхлэх цаг, үргэлжлэх цаг, дахин давтагдах цаг, харьцангуй цаг, ерөнхий ба тусгай цаг) заасан үгс хоорондоо хоршино. Тухайлбал:

А. - а. орших орон

1. баруун зүүн ~зүүн баруун, өрнө дорно

-Цэрмаа, Чүлтэмээс салан гэрт орвол бурхны өмнө унийг тултал боов өрж тахил тавиад, тулганы *баруун зүүн* этгээдэд хэд хэдэн зүйлийн тавагтай идээ ба ууц мах, банш буузыг хуучин ёсоор тавьжээ. (Д.Н)

-Зүүн *баруун* өнхөрөн байлдах нь өчүүхэн ч сэв гаргахгүй. (В.И)

2. өмнө хойно~ хойно өмнө, өмнө умар, өмнө дорно~дорно өмнө, хойно урд ~урд хойно, урд хойд, өвөр ар~ар өвөр, дорно өмнө

- Гар хөл *ар өвөрт* залган өмсөнө. (В.И)

- Баруун зүүн *өмнө умар* дөрвөн зүгт дайлахуйяа. (В.И)

- Баруун тангадын *өмнө хойно* бүхий Ши иү улс олон аймгууд самууран... (В.И)

- Дайлж дагуулсан олон аймаг улсыг хянан залган байцааж, дэс зэргийг тогтоон харилцан чармайлцахыг хөгжүүлж, одоо *өмнө дорныг* дайлахыг зөвлөхөд Тайзу баясан захиран... (В.И)

-Хун галуу хос хосоор залгалдан сүрэг сүргээр хэлхээлээд *дорно өмнө* зүг нисэн эчихүйд нутаг усандаа татагдан... (В.И)

-Бэр нь хонио бэлчээгээд *урд хойно* нь орж, хормой хотноос нь зүүгдсэн хүүгээ тэврэн пин рүү очив. (Д. Г)

3. дээр доор~доор дээр, дээд доод~доод дээд, өөд уруу~уруу өөд гэхэд дөрвөн зүг, найман зовхисийн ойлголт нь тэгш хэмтэйгээр эсрэгцэлдэн хоршихын зэрэгцээ дээд доод гэсэн зүг ч мөн хоршин илэрч буй чанар нь эсрэг тэсрэгүүд харилцан шилжих холбоог үүсгэх бөгөөд эсрэг тэсрэгийн тэгш хэмтэй тэнцвэр алдагдвал тэр нь өөрийгөө нөхнө гэсэн үг юм. Харин дээр дунд, доор дунд гэж хоршихгүй байгаа нь дээр, доор гэх үг нь туйлын ойлголт боловч дунд гэх үгийн талаас харьцангуй ойлголт болно. Дээр, дунд, доор гэх гурван үг нь тус бүртээ харьцангуй бие даасан чанартай боловч хоорондоо үйлчлэх хүч, давтамжаар харилцан адилгүй хэлхээ холбоогоор нягт барилдсан байдаг.

- Гагцхүү барималчийн нүд чавчихгүй цоо ширтэх харцтай харц мөргөлдөх үед л бие баригдах тул аль болохоор түүнээс харц буруулан тасалгааны доторх гартай гаргүй хүний баримал, толгойг нь уруу өөд харуулж тавьсан зургууд, шал цонхны тавцангүй хөглөрөх сонин сэтгүүлийг харж, яагаад энэ хүний зургийг толгойг нь уруу нь харуулж тавьсан юм бол доо гэж бодож суув. (Д. Б)

4. энд тэнд (орон цагийг төлөөлсөн төлөөний үг), наана цаана~цаана наана, наад цаад~цаад наад, ил далд, төв дунд, инад чинад зэрэг орон зайн алслал заасан үгс, мөн тодорхой эзэлхүүнт биеийн түвшинд илэрнэ.

-Энд тэнд явж юм үзмээр бодогдлоо, эргүүлж тойруулж бодвол хол явчмаар санагдлаа. (Ц. Д)

-Наад голын нарс

Цаад голын царс

Нар шингэхийн үед

Намгаараа нийлнэ (нүд, сормуус, унтах)

-Цаанаа ч шалз

Наанаа ч шалз (ханын үдээр)

-Энд мөнгөн таваг

Тэнд модон таваг (үхрийн аргал)

5. эзэлхүүнт орон илрэхдээ дотно гадна~гадна дотно, дотор гадар~гадар дотор, дотоод гадаад~гадаад дотоод гэх мэтээр тэгш хэмтэй харьцангуй утгаар хорших боломжтой.

-Гадаад дотоод зуун түшмэд зуун түмэн наст хэмээн тэнгэрийн хишигт мөргөв. (В.И)

-Бага эздэд хүчээ барь хэмээн дотоод гадаад олон жанжин нар үнэхээр бишрэн гайхаж мөргөв. (В.И)

-Гал голомтонд шаант орхин тахиулж, Халдун ууланд цацал өргүүлэн мөргүүлээд гадна дотно ах захаст ёслуулаад гар хөлийн ураг садныг цөм таниулсан хойно... (В.И)

-Энгүдийн цэрэг цөм ар өвөр дайсанд хаагдаж дотор гаднаас харвах нь бороо орох мэт. (В.И)

6. Гэтэл баруун урд, өрнө өмнө, баруун хойно, өрнө умар, баруун хойд, зүүн урд, зүүн хойно, зүүн хойд зэрэг хавсарсан үгс нь дээрх үгс шиг тонгорч байр сэлгэх боломжгүй жишээ нь: баруун зүүн ~зүүн баруун гэж болж байхад харин “зүүн урд” гэсэн үг, “урд зүүн” гэж болохгүй байна. Энэ нь хоёр чиглэлт гурван хэмжээсийн үгс нь харилцан эсрэгцэн тонгордог бол харин баруун хойд, баруун урд, зүүн хойно, зүүн урд зэрэг үгс нь баруун- хойно, баруун- өмнө, зүүн- хойно, зүүн-урд гэсэн хоёр зүгийн эсрэгцэл дунд илрэхдээ хоёр чиглэлт хоёр өөр хэмжээсийн дундын эсрэгцэл шинжтэй байна. Энэ нь хүн өөрөөсөө гадагш ертөнцийн орон зайн баримжааг илэрхийлэхдээ баруун зүүн, урд хойно улмаар дөрвөн зүг найман зовхис гарган цааш нь тэгш хэмд хуваан үзжээ. Мөн дорно өмнө зүг харвасан мэт, баруун хойд талын гэр, зүүн хойд булан гэх мэтээр нэрийн өмнө тодотгож хэлзүйжсэн шинжтэй, хувиргахад зөвхөн арын үг нь хувирдаг.

7. хажууд, дэргэд, зэргэд, зуур, дунд, хооронд гэх мэт үгс нь хоорондоо хоршихгүй бөгөөд өөр үгтэй орвол туслах үг, эсвэл холбох үүргээр орж орон цагийг утгыг илэрхийлнэ. Энэ нь утгаараа хоёр талын хязгаарыг заагаагүй тул хоршихгүй гэж болно.

Орон цагийн нэр хоршихдоо -на, -р, -д(-т) дагавар авбал юм үзэгдлийн орших тодорхой орон цагийг заах бол -ш, -гш дагаврын тусламжтайгаар төвөөс зах руу, захаас

төв рүү чиглэх тодорхой хөдөлгөөн, -уур(-үүр), -аар(-ээр) дагавар авч юм үзэгдлийн хөдлөнги, тодорхойгүй зүг заан хорших боломжтой.

А. б. хөдлөх орон (а. тодорхой зүгт, б. тодорхойгүй зүгт)

1. баруунтаа зүүнтээ

2. урагш хойш~хойш урагш, өмнүүр хойгуур, урдуур хойгуур~хойгуур урдуур

-Баруунтаа суусан хүүхний хөөрхнийг хэлэх үү

Пялан дотор байгаа махны сайхныг хэлэх үү

Хорхойг хөдөлгөсөн түүний нүд хоёр биен дээр ээлжлэн тусахад

Хойгуур урдуур суусан хүүхдийн, шивэр авир ярилцах нь хэцүү(Д.Н)

-Хос хар морь уралдаад

Хойно урдаа орно (хүн явах) гэх мэтээр шууд хоршсон

-*Хойноос* ирсэн хүн

Хэлэн дээрээ бичигтэй

Урдаас ирсэн хүн

Улан доороо бичигтэй (хийморь)

-Шилэн эвэр ийш тийшээ

Хонин эвэр *хойш урагшаа* (ханын толгой)

-Эх сүүл хурц үгүй, дохио тэмдэг өл сөл, туг хиур *урагш хойшид* Тайзу Хасарыг дуудаж өгүүлрүүн. (В.И)

3. дээш доош~доош дээш, дээгүүр доогуур~доогуур дээгүүр, өөд уруу

-*Доогуур* идэж

Дээгүүр баадаг

Нэг ам

Хоёр чих (харуул)

4. ийш тийш, үүгээр түүгээр, энэтээ тэртээ, нааш цааш~цааш нааш, наагуур цаагуур~цаагуур наагуур, инагш чинагш, инару чинару

-Тэр хүүхэд нүдээ бүлтийтэл галаа үлээж нөмгөн дээлтэй чичрэн дагжин *ийш тийш* самгардан байтал, түүний хэвтшийн шар эсгий дэвсгэрийн дээрх дахны дороос тас хийтэл авиа гарч жаахан хүүхэд чөлөө завгүй уйлан эхлэв. (Д.Н)

-Хойд уулын энгэрээр дун цагаан цас гялтганан түүний зах сэжүүр нь сэмэрч борлосныг харахад, энэ үе өвлийн хүйтэнд онд орж ядарсан эцэнхий туранхай үхэр мал *үүгээр түүгээр* сүүлээ шарван явцгаадаг нь санагдаж, тэсгэм хүйтний илч хариад хаврын сайхан улирал ирж байгаа нь мэдэгдэн хэдийгээр тааламжтай сайн боловч... (Д.Н)

- Нэгэнтээ харавсанд чив хийтэл Тоймогийн аман хүзүүгээр шувт *энэтээ тэртээ* хагас хагас газар унатал, олон цэрэг тэнгэрээс сум буув хэмээн айлдаж самуурав. (В.И)

-*Үүгээр түүгээр* адуу мал зөндөө бэлчээд, үе үе тохиолдох айлын зэл дээр бариатай гүүнүүд янцгааж айраг, найрын цаг мэдэгдэвч дайран орж зугаацах чөлөө хаа байна. (Д.Н)

-*Үүгээр түүгээр* хэдэн тугал оодогнон давхина. (Д.Н)

- Ийм цэвэр гоёмсог газар, ширүүн амьсгалах ба *нааш цааш* явах гэгч дур зоригоор болохгүй үнэхээр гайхамшигтай. (Д.Н)

-*Нааш цааш* сүлжсэн тэнгэр сайхан нуруутай гэх мэтээр тухайн нэрийн болон үйлийн болох орон зай, цаг хугацааг илэрхийлэхдээ хоршоо үгийг хэргэлсэн нь зохиогчийн туурвисан бүтээл хүний сэтгэлд ойр буух нэг үндэс нь төдийгүй монгол хэлний хоршоо үгийн донж зохицлыг тохируулж нэгэн цогц ойлголтыг илэрхийлжээ.(Д.Н)

-Орой ангидаа суугаад давтлага хийхэд онгорхой хаалгаараа чамайг хараасай гэж цааш нааш мөн ч олон гардагсан. (Ж. Л)

5. дотогш гадагш~гадагш дотогш, дотуур гадуур~гадуур дотуур

-Гадуур дотуур баг орныхоо ажлаар оролдоод зав зайгүй гэж хүүхэн тайлбарлав. (Ш. Г)

6. баруун урагш, баруун хойш, баруун урдуур, баруун хойгуур, зүүн урагш, зүүн урдуур, зүүн хойш, зүүн хойгуур гэж хавсарч орж болно.

7. зэргэд, зуур гэх үгс нь дагавар авч хэлбэржихгүй харин хажуу, дэргэд, дунд, хооронд зэрэг үгс нь -уур (-үүр) дагавар авах боловч орон цагийн нэртэйгээ хорших боломжгүй байна. Жич, тэгш хэмтэй хоршиж буй зарим орон цагийн нэр “-гүй” гэсэн залгавар авч тодорхой бус утга илэрхийлнэ. Тухайлбал, энд тэндгүй, дээр дооргүй, урд хойногүй, баруун зүүнгүй, наана цаанагүй, наад цаадгүй, дээгүүр доогуургүй, гадна дотногүй, хаа хаагүй гэх мэтээр эсрэг, ойролцоо орон цагийн нэр хоршихоос гадна зарим тохиолдолд бүрэн давтаж хоршиж болдог тухайлбал дотор дотор, дор дороо, дээр дээрээ, доор доороо, хойно хойноо, урд урдаа

-Дотор дотроо гайхалдан Тайзугийн дэргэд бэлтгэж байсан тул... (В.И) гэх мэт.

Монголчууд орон цагийг үзэхдээ зурхайн ухаанд тэгш тоот хуваарийг, цаглахуйн ухаанд ихэвчлэн сондгой тоон ойлголтыг авч үзэж байсан нь ч монгол хэлнээ орон цагийн нэр дан буюу дундын шинжтэй болон хорших үзэгдлээс харагдаж байна.

Орон зайн хувьд харьцангуй ба туйлын хугацааны концепцийг хэрэглэдэг бөгөөд ерөнхийдөө энгийн харилцаанд цаг хугацаа орон зайтай шууд уялдан гарч ирдэг. Цаг хугацаа нь хуваагддаг тоон хэмжээстэй тул бид цаг хугацааг нэг урсгалд өнгөрдөг гэж үзвэл зөвхөн ерөнхий цагийг л илэрхийлэх боломжтой, харин цаг хугацааг гурван хэмжээст оруулан тодорхой цаг болон түүний хуваагдлыг гарган, эсвэл цикл хэлбэрт авч үзвэл олон боломж гарч ирнэ. Иймд хугацааны концепци харилцаанд орон цагийн нэрээр илрэхдээ:

Б. 1. эрт урьд, эрт эдүгээ, эрт одоо, эрт өдгөө, эрт орой, урьд хожид, үргэлж мөнх, ашид мөнх, ашид үүрд, өнө мөнх, өнөд үүрд, үүрд мөнх, хожим хойно, хэзээ ямагт, түр зуур, хааяа заримдаа, даруй мөдхөн, үтэр даруй гэх мэт хорших хэлбэрээр илэрнэ.

-Тийм зүйлийг урьд хожид үзээгүй тул хэзээ хагалах огтлох бол гэхэд бүхий биеэр хүйтэн хөлс асгарахад, аргацаан харж байвал, өнөөх өвчтэй хүний шаргал цагаан нүүр нь дун цагаан болж үг хэлэхийн сэхээгүй дэмий л хоёр нүдээ эргэлдүүлэн энэ тэрийг ширтэнэ. (Д.Н)

-Өнгөрсөн-одоо- ирээдүй

Өнө мөнх эргэнэ. (Д. Урианхай)

-Эелдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд

Эрт эдүгээг бодогдуулан, нуугдсан сэтгэлийг сэргээнэ. (Д.Н)

-Баатар гэгч үргэлж биш

Баян гэгч үүрд биш

-Хатуужиж явбал

Ашид тустай

Үнэнч явбал

Үүрд тустай

- эрт урьд сайд би энд ахуй үед энэ харанхуй ойт ууланд энэ нарийн замаар ордог бөлгөө (В.И)

-Асралт соёлт бугын соёо ашид үүрдийн сургаал (В.И)

- Ийм үгийг сайхан хэл эрт орой таны газарт хүрнэ. (В.И) гэх мэт.

Эндээс ажиглавал дэлхий нь тэнхлэгээрээ эргэж нарыг тойрдог тул өргөрөгт буй ойлголт нь харьцангуй харин дэлхий уртрагийн дагуу эргэдэггүй тул үүнийг хэлэнд тодорхой хэмжээгээр тусгаж, мөнх гэсэн цагийн утгат үгийг мөнх тэнгэр хэмээн хоршин хэрэглэж ирсэн бололтой.

2. орон цагийн нэрээс гадна цагийн утгатай үгс хорших тохиолдол түгээмэл байна. Жишээ нь: хором мөч, агшин зуур, цаг үргэлж, өдөр хоног, хоног сар, сар жил, эрин зуун, зуун жаран, эрин галав, өчигдөр өнөөдөр, өнөөдөр маргааш, өнөө маргааш, маргааш нөгөөдөр, өвөл зун, намар хавар, намар өвөл, хавар зун, зун намар, өвөл хавар, өглөө орой, орой үдэш, өдөр шөнө, хором хормоор гэх мэт. Цагийн ойлголт нь хуваагддаг хэмжигдэхүүнтэй тул тодорхой хугацааны нэгжийг эдгээр үгс нь заан нэрлэсэн шинжтэй бол орон цагийн нэр нь юм үзэгдлийн хэзээ, хаана болж буй орон цагийг тодруулсан шинжтэй тул өгүүлбэрт цаашилбал эхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ийм учраас ямарваа хэлийг хоёрдогч хэл болгон заахад орон цагийн нэр хамгийн бэрхшээлтэй байдаг.

-Өмнө хойноос харж үзэхэд

Өнгө үзэсгэлэн төгөлдөр бөгөөд

Өвөл зун хэдийд ч уйтгаргүй

Өргөн дэлгэр дайдуу минь (Тогоонтөмөр хааны гэмшлийн шүлэг)

3. эрт дээр, урьд өмнө, хожим хойно, зуур хооронд гэх мэтээр зарим орон цагийн нэр нь энэ нь орны, тэр нь цагийн нэр гэж ялгах боломжгүй орны нэр нь зөвхөн хэлбэр нь адил боловч утгаараа цагийг илэрхийлэх нь орон ба цагийн утга нь салгаж үзэх боломжгүй хэвшин тогтсонг хэлний баримтаас ажиглаж болохоор байна.

-Энэ үе удаа дараа хүрч ирсэн хүмүүс түүнийг гайхан магтах бөгөөд шувуун саарал гэж нэрийдэн, Сүрэнхүүгээс шалж, өдий төдий залуу тарган морины үнэ хаялцана. (Д.Н)

- Энэ хирд Алтан улсын Дүн гуваныг сахисан их жанжин Ли пин боомтоо Монголд өргөж мөргөн дагасанд Монголын цэрэг дараа дараагаар далайн давалгаа мэт орж ирээд...(В.И)

- Урьд өмнө өдөр ганцаараа байх нь битгий хэл, шөнө ганцаараа бишгүй л хонодог доо. (Д. Б)

4. эрт оройгүй, өглөө үдэшгүй, өглөө оройгүй, өнөө маргаашгүй, урьд хожидгүй, эрт эдүүтээгүй, хэзээ хэзээгүй, хэзээ язаагүй гэх мэтээр орон цагийн хоршоо үг нь -гүй нөхцөлөөр харьцаа заана.

Давталт нь үг, үндэс, язгуур, морфем зэргийг байгаа хэлбэрээр нь давтах, хэл зүйн хэлбэрээр хувирган давтах зэрэг олон хэлбэртэй байхаас гадна үг бүтээх, хэл зүйн утга илтгэх, өгүүлэгч этгээдийн сэтгэлийн хөдөлгөөний өнгө аяс илтгэх, юм үзэгдлийн тоо хэмжээ заах, үйлийн болц байдлыг заах зэрэг олон янзын агуулга, үүрэгтэй байдаг байна.⁸

Т.А. Бертагаев “үе үе, дараа дараа” зэрэг давтсан үг нь хэлзүйн утга илтгэнэ гээд, “гуйбар гайбар, няс тас, гард түрд, аруу таруу” зэргийг хоршоо үгс /биномы/⁹ гэж эдгээр үгсийг хоршоо үгээс ялган давтсан үгэнд хамруулан үзжээ.

Ижил давтагдаж байгаа нэр үгийн нэгдүгээр нь голдуу үндсээрээ байх боловч жил, өдөр цаг гэх мэт хугацаа заасан цөөн үг жилийн жилд, үеийн үед, өдрөөс өдөрт, жилээс жилд, үрийн үр гэх мэт харьяалах, гарахын тийн ялгалаар хэлбэржсэн байдаг...

⁸ Розенталь Д.Э., Теленков М.А. Справочник лингвистических терминов. М., 1972. стр. 262

⁹ Бертагаев Т.А. Сочитания слов и современная терминология. М., 1971, стр. 33

дээр дээр үсрэх гэх мэт зүйл хааяа тохиолдох боловч орон цагийн харьцааны нэр ижил хэлбэрээр бараг давтагдахгүй бололтой.¹⁰ гэжээ. Эндээс үзэхэд орон цагийн нэр давтан орж хэлзүйжсэн тохиолдол зөвхөн ярианы хэлэнд л (надад энийг орчуулаад өг дөө. – дараа дараа, одоо надад зав алга, бүжин туулай дээр дээр дэгдэн үсэрнэ.) цөөн тохиолдолд илрэх бөгөөд харин орон цагийн утгат үгс давтан хэрэглэгдэх боломж байна. Жишээ нь: үе үе, үе үехэн, дараа дараа, хааяа хааяа, хаа хаа гэх мэт.

Утга ойролцоо хоршоо үг нь хүн ардын соёл, эдийн засгийн хөгжилтэй уялдан гардаг ба зарим нь нэр томьёоны чанартай болж байгаа нь ч бий. Ер нь нь утга ойролцоо хоршоо үг монгол хэлний зүй тогтлын дагуу тус хэлний сэтгэхүй болон хүмүүсийн соёл, эдийн засгийн хүрэнээ нягт холбоотойгоор үүссэн байдаг бололтой.¹¹ Харин орон цагийн нэр хоршиход нэр томьёоны шинжтэй үг үүсдэггүй бөгөөд ерөнхийдөө монгол хэлний уугуул үгс хоршихын зэрэгцээ харь хэлний үгтэй орны нэр хоршсон жишээ тохиолдоогүй бол харин цагийн хэмжигдэхүүн заасан зарим үг харь хэлний ойролцоо үгтэй хоршин хэрэглэгдэж байна. Үүнээс үзвэл хоршоо үг бүтэхдээ дотоод нарийн зүй тогтолтой байдаг нь өгүүлбэр зүйн холбогдолтой ба ертөнцийн зүй тогтол хэлэнд логиктой илрэх хэлбэр гэж болно.

Германы физикч Макс фон Лауэ “Хүн төрөлхтний сэтгэлийг догдлуулж буй хамгийн гол зүйл бол орон цагийн мөн чанарын тухай асуудал юм” гэжээ. Мөн Ленинградын астрофизикч Козырев 1960-аад онд “цаг хугацаа нь орчлонгийн устаж алга болдоггүй хамгийн гол бодит зүйл бөгөөд гэрэл болон материйг үүсгэдэг аж.” ... иймд цаг хугацаа (бидний ойлголтоор: өнгөрсөн-одоо-ирээдүй) нь нэгэн зэрэг оршиж байдаг, яагаад гэвэл хэрэв бид цаг хугацааг дэс дараатай явагддаг гэж үздэг бол цаг хугацааны энгийн явцын эсрэг үүсэн гарсан байна гэжээ.

Хэлний агуулгын судалгаа нь үг, холбоо үгийн утга өргөсөх, тэдгээрийн дотоод харьцааг судалдаг хэлбэрийн судалгаанаас юугаараа ялгаатай вэ гэвэл хэлний нэгжүүд гадаад ертөнцийн юм үзэгдэлтэй хэрхэн холбогдох, юмс үзэгдлийг хэрхэн нэрлэх хэрэглүүр болдгийг судалдагт оршино.

Б. Ринчен хоршоо үгийн зүйл монгол сэтгэхүйн үүднээс, мөн монгол ардын утга соёлын үүднээс тун сонин санагдаж, манай ардын сэтгэхүйн ертөнцийг үзүүлдэг гээд хоршоо үгийг 1. авиан зүйн үүднээс толгой холбосон хоршоо үг (цагт нэр толгой хорших) 2. сүүл холбосон хоршоо үг (нөхцөл хорших хоршоо үг) 3. дууриан хоршоо үг 4. утга ойролцоо хоршоо үг (цагт нэрээр хоршоо үг бүтэх, сул нэр хорших) 5. эсрэг тэсрэг хоршоо үг (цагт нэрээр хоршоо үг бүтэх) 6. аялга хоршоо үг 7. үгүйсгэл хоршоо үг (цагт нэрнээ орох үгүйсгэх эсрэг тэсрэг хоршоо үг) 8. давтах хоршоо үг (давтац хоршоо үг) 9. элдэв хоршоо үг” гэх мэтээр утга бүтцийн талаас нь ангилжээ.¹²

Харин Ж. Баянсан “Монгол хэлний хоршоо үг нь бүтцийн өөр өөр хэв шинжтэй ч гэсэн нэг бол өгүүлүүрийн үйл ажиллагааны хэмнэлийг дагасан эсвэл ухамсарлахуй, танин мэдэхүй, амьдралын мэдлэг туршлагын үр дүн болох ухагдахуун ойлголтын хоорондох харьцаа хамаарлаар жишин адилсуулж, авалцуулан холбох үгүй бол энэ хоёрын аль альны нь хослуулах зэргээр сэтгэц, сэтгэлгээний үйл явц, үр дүн болж үүсдэг зүй тогтолтой бөгөөд хэлний хэмнэлийн зарчмын нэг содон илэрхийлэл юм.”¹³

¹⁰ Бямбасан П. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Уб., 2006, 345 дугаар тал

¹¹ Алтангэрэл Д. Монгол хэлний хоршоо үгийн тухай товчхон өгүүлэхэд. “Шинжлэх ухаан амьдрал” сэтгүүл. Уб., 1983. 33 дугаар тал

¹² Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Уб., 1967, 20 дугаар тал

¹³ Баянсан Ж. Соёл хэл, үндэстний сэтгэлгээ. Уб., 2002, 72 дугаар тал

гэж монгол хэлний хоршоо үгийн онцлогыг сэтгэц хэл шинжлэлийн үүднээс олон жишээ баримт ашиглан тайлбарлажээ.

Монголчуудын газрын зураг үйлддэг аргын талаар товч танилцуулсу. Үүнд, Монголчууд газрын зургаа үйлдэхдээ зургын суурь үндэс болгож тойрог татан тойргоо дөрвөн зүг, найман өнгө, найман өнцөг, дөрвөн зовхис гэж 24 хуваагаад энэ хуваарь тус бүрийн завсар хэмээж бүгд 48 болгодог уламжлалтай байжээ.¹⁴ гэсэн нь орон цагийн ойлголтыг ойлгоход нэлээд дөхөм болно.

Үүнээс үзвэл хэлний нарийн ээдрээтэй зарим үзэгдлийг зөвхөн хэл шинжлэлийн талаас тайлбарлахад бэрхтэй тул олон шинжлэх ухааны зааг буюу хавсарга шинжлэх ухааны түвшинд судалбал тодорхой болж болно. Ер нь хэн нэгнээс орон цагийн ойлголт хэлэнд хэрхэн илэрч буйг асуувал үүнийг ямар нэг үг, өдөр тутмын мэдлэг, ойлголтоор тайлбарлах боломжгүй юм. Харин энэ нь хэлний баримтанд хэрхэн илэрч байгааг ажиглавал зарим хэвшин тогтсон хэллэг нь тухайн хэлт ард түмний соёл, угсаатны онцлог, ертөнцийг үзэх үзэлтэй нь салшгүй холбогдсон байдгийг мэдэж болно. Тухайлбал, Л. Балдан, Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулгыг судлаад: 1. Байгалийн үзэгдэл, амьтны хүйсийг нэрлэсэн үгс, 2. Аливаа юмны шинж чанарыг ялган заасан үгс, 3. Хийж үйлдэх хөдөлгөөнийг заасан үйл үг, 4. Зүг чиг, цаг хугацааны харьцаа заасан үгийг хооронд нь утга эсрэгцүүлэн холбосон байна. Утга эсрэгцэж байгаа хоёр үгийг ажиглан үзэхэд эхнийх нь үг голдуу эерэг утгатай, сүүлчийнх нь үг эхний үгээ утгаар нь багасгаж бууруулсан шинжтэй байна гээд мөн уран зохиолын хэллэгт эсрэг утгатай хоёр үгийг өгүүлбэрт байрлуулахдаа онцолсон үгийг нь түрүүнд нь бичдэг¹⁵ гэжээ. Энэ нь орон цагийн нэр хоршоо үгээр илрэхдээ баруунаас зүүн, дээрээс доош, өмнөөс хойш орон зүг зааж, баруун зүүн тийш эргэх хөдөлгөөнийг нь баруун тийш эргэх гэдэг нь нар зөв эргэх гэсэн эерэг ойлголт харин зүүн тийш эргэх нь сөрөг ойлголт мэт боловч энэ нь мөнхийн эргэлт лүгээ адил тул харьцангуй ойлголт төдийгүй тухайн ард түмний тэр тусмаа монгол хүний орон цагийг үзэх эерэг сөрөг ойлголтонд юуг хэрхэн багтаах үнэлэмж нь цагийн холбогдолт үгэнд тэгш ба сондгой хуваагдах шинж бүхий үгсийн утга учрыг ухан гаргахад хэрэгтэй. Үүнийг зөвхөн хэлний талаас тайлбарлах боломжгүй тул хэл соёл, угсаатны зүйн талаас нарийн судалгаа шаардах тул энд цухас дурдлаа.

Эндээс үзвэл дээрх эрдэмтэн мэргэдийн судлан шинжилсэн зүйлд тулгуурлан орон цагийн нэрийн хоршоо үгийн онцлогийг тунгаан үзвэл:

-Орших орон заасан үгс тодорхой ба тодорхойгүй зүг илэрхийлэхэд хоёр үг зэрэг хувилдаг бол ерөнхий ба тодорхой цаг заасан үгсийн хоёр дах үг нь л хувилдаг.

-Тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр зарим үг нь хувилж зарим нь огт хувилахгүй тул ихэвчлэн үндсээрээ хоршсон байна.

-Орон цагийн нэрийн зарим хоршсон үгэнд -х(-хи), -хан(-хэн,-хон,-хөн), -гүй залгавар залгаж болно.

-Өгүүлбэрт нэр, үйлийн өмнө тохиолдож, өгүүлбэрт харьцангуй чөлөөтэй байрлаж, ихэвчлэн байц гишүүний үүргээр орж, заримдаа туслах үгийн үүргээр орж буй нь үзэгдэл судлалтай холбогдоно. Орон цагийн нэр хоршсон хэлбэр-үйл үг, харьяалахын тийн ялгалаар хувилсан нэр үг-орон цагийн нэрийн хоршоо үг-үйл үг,

¹⁴ Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. Уб., 2003. 16 дугаар тал

¹⁵ Балдан Л. Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулгын зарим онцлог. Уб., 1978, 121-122 дугаар тал

харьяалахын тийн ялгалаар хувилсан нэр үг-орон цагийн нэрийн хоршоо үг-нэр үг-үйл үг гэх хэлбэрээр өгүүлбэрт хоршсон хэлбэр нь тохиолдож байна.

-шууд утгаар хоршсон орон цагийн нэр

-Ишигний эвэр *ийшээ тийшээ*

Хонины эвэр *хойшоо урагшаа* (ханын толгой)

-Хос хар морь уралдаад

Хойно урдаа орно (хүн явах)

-утгаараа алгасан хоршсон шууд бус нэрлэлт бүтээх эх үндэс болно.

- *Хойноос* ирсэн хүн

Хэлэн дээрээ бичигтэй

Урдаас ирсэн хүн

Улан доороо бичигтэй (хийморь)

-Мянган лангийн *дотортой*

Мяндас модон *гадартай*

Түмэн лангийн *дотортой*

Түлш модон *гадартай* (хунзтай цай)

-Орон цагийн нэр хоршиход авианы хувьд толгой холбосон байдал цөөн тохиолдох бөгөөд зөвхөн бичил эх, цогцолборын түвшинд л мөрийн толгойг зэргэд эсвэл салаавчилсан байдлаар шүлгийн толгой, сүүл холбоход утгын хувьд нэгдэн илрэнэ.

-*Дээр нь* суусан

Дэнхэр ноён

Доор нь суусан

Донхор ноён

Уруу харсан унхар ноён

Удмаа дуурайсан ширээн ноён (тогоо нэрэх)

-Өгүүлбэр зүйн талаас зэргэд өгүүлбэр бүтээх гол нэгжийн үүрэг гүйцэтгэх боломж орон цагийн нэрд ч ажиглагддаг.

-Миний гэдэс *өмнөө* байхад

Чихний гэдэс *хойноо* байна (хөлийн шилбэ)

-Хамаг амьтны гэдэс *урдаа* байхад

Зантгар зааны гэдэс *ардаа* байхад (хөлийн шилбэ) гэх мэт.

--захын дэлгэрүүлэгч орны байцын үүргээр:

-*Урьд* гарсан чихнээс

Хойно гарсан эвэр

--захын дэлгэрүүлэгч нь туслах үүргээр:

-Тээр *дээр* дэлэгнээд

Энэ *доор* саалгана (үүлшиж бороо орох)

-Газар *дээр*

Гээзэг

Газар доор

Ганц хурга (манжин)

--Хамжсан тодотголын үүргээр:

-Дохилдай шувуу

Доод нуурт очиж ундлаад

Дээд нуурт гарч

Мөрөө үзүүлнэ. (бийрээр бичих)

-Ар талыг арлаад
Өвөр талыг өвөрлөөд
Өөд уруугүй шогших (ном унших)

-- орны байц захын дэлгэрүүлэгч гишүүн, өгүүлэхүүн нь тэгээр илэрчээ.

-Ойн хар модны
Үзүүр нь доошоо
Ёзоор нь дээшээ (гээг)
-Хороо нь дотроо

Хонь нь гаднаа (сувдан даруулга) гэх мэт.

-Нийгмийн хөгжил хувьслыг даган заримдаа хоршоо үг шинээр үүсдэг бол орон цагийн нэрийн хоршоо үг нь харьцангуй тогтвортой байдаг.

-орон цагийн нэр нь дутмаг хувилдаг онцлогтой, энэ нь орон цагийн нэрийн хоршоо үгэнд ч адил байна.

-дээгүүр доогуур гүйх, дээгүүр доогуур ярих гэх мэтээр заримдаа үйл үгийн өмнө хоршин орохдоо шууд бус утгаар илрэх, мөн ярианы хэлэнд эхнийх нь эгшиг бол ~м, с~м, ш, т, з-ээр солин хорших хэлбэр тохиолдоно.

-орон цагийн нэрийн хоршоо үгийг зөв ухаарах нь монгол хэлийг хоёрдогч хэлээр сурах болон орчуулахад чухал төдийгүй эх болон толь бичгээс зөв харж, тухайн хэлний утгын зохицол дах (mentalen Lexikon) шууд ба шилжсэн утгыг ойлгох, мөн орон цагийн нэр нь ямар нөхцөлөөр хувилсанаас бус харин өгүүлбэрт бусад үгстэй хэрхэн харьцаж байгаагаас утга нь тодорно.

- орон цагийн нэр утгын хувьд хорших нь тус бүр эсрэг тэсрэг утгатай, юмс үзэгдлийн орших орон байр, үйл хөдлөлийн чиглэл харилцан эсрэг, цаг хугацааг заан нэрлэсэн үгс эсрэгцэх, утга ойролцоо үгс хоршин нэг үгийн утга санааг нөхөн бүрэлдүүлж хоёр үгээр тухайн мэдэгдэхүүнийг тодорхой болгох, мөн давтах, залгавар адил хорших зэрэг бодот юм үзэгдэл-бодот юм үзэгдэлтэй, бодот-хийсвэр, хийсвэр-хийсвэр зүйлстэй харьцахад орон цагийн нэр нь хэлний хийсвэрлэлийн үр дүнд хоршиж хийсвэр утгыг гаргана.

Дүгнэлт

Хэдийгээр орон цагийн нэр өөр хоорондоо хорших нь монгол хэлэнд цөөн байгаа боловч орон цагийн ойлголтуудыг хослон багтааснаараа сонирхолтой юм.

Ер нь ертөнц дээр буй юмс үзэгдэл орон цагаас ангид орших аргагүй юм. Орон цагийн нэрийн хоршсон хэлбэрийг судлах нь монгол хэлийг заахад хэлний хэрэглээний чадварыг хөгжүүлэхэд чухал юм. Мөн хүн төрөлхтөний сэтгэхүй дэх орон цагийн ойлголт хэлэнд хэрхэн илэрдгийг харьцуулах, зэрэгцүүлэн судлах цаашилбал монгол хэлний орон цагийн нэр өөр хоорондоо болон бусад үгсийн аймагтай хэрхэн хоршиж буй хэлбэр, бүтэц, утга үүргийн хэв шинжийг гаргах нь чухал ач холбогдолтой юм.

Ном зүй

1. Алтангэрэл Д. Монгол хэлний хоршоо үгийн тухай товчхон өгүүлэхэд "Шинжлэх ухаан амьдрал" сэтгүүл. Уб., 1983
2. Базаррагчаа М. Монгол хэлний хоршоо үгийг хэрэглэх тухайд. Уб., 1990
3. Базаррагчаа М., Идэрбаяр Б. Монгол хэлний хоршоо үг. Уб., 1993
4. Баасанбат Д "Хөх судар"-ын хоршоо үгийн сан. Уб., 2006

5. Балдан Л. Д. “Нацагдоржийн зохиолын хэл найруулгын зарим онцлог”. Уб., 1978
6. Барайшир Ш. Орчин цагийн монгол хэлний дайвар үг. Уб., 1974
7. Бат-Ирээдүй Ж. Монгол хэлний хоршоо үгийн товч толь бичиг. Уб., 2008
8. Баянсан Ж. Соёл хэл, үндэстний сэтгэлгээ. Уб., 2002
9. Бертагаев Т.А. Сочитания слов и современная терминология. М., 1971
10. Бямбасан П. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Уб., 2006
11. Лувсанвандан Ш ба Дэмчигдорж Б. Монгол хэлний зүй -I, Уб., 1951. 50 тал
12. Лувсанвандан Ш. Орчин цагийн монгол хэл. ӨМАХХ., 1959
13. Монгол ярианы хэл зүй. Эрхилсэн найруулагч: Хас- Эрдэнэ, Сэцэн. ӨМАХХ., 2006
14. Өнөрбаян Ц. Орчин цагийн монгол хэлний үг зүй. Уб., 2004
15. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй. Дөтгөөр дэвтэр, Өгүүлбэр зүй. Уб., 1967
16. Розенталь Д.Э., Теленкова М.А. Словарь справочник лингвистических терминов. М., 1976.
17. Санжеев Г. Д. Грамматика бурят- монгольского языка. М., 1941
18. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966
19. Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. Уб., 2003
20. Gerhard Helbic. Deutsche Grammatik. iudicium verlag GmbH, Muenchen., 1991

Ашигласан эх зохиол

1. Д. Нацагдорж Түүвэр зохиол
2. В. Инжиннаши “Хөх судар”
3. Д. Батбаяр “Мөнхрөх хүсэл”
4. Д. Батбаяр “Үл үзэгдэгч”
5. Ш. Гаадамба “Элбэг дээл”
6. Д. Гармаа “Чонын үүр”
7. Ж. Лхагва “Хайрын зурвас”
8. Ц. Дамдинсүрэн “Буурал ээж”
9. Г.Ринченсамбуу “Монгол хэлний зүйр цэцэн үгийн далай”

SUMMARY

The article is concerned with the use of relative adjectives expressing quality in relation to the abstract or generalized concept and action in oral scientific speech.

Although there are a few occurrences of binary names of place and time in Mongolian language, it is interesting here those concepts of place and time are combined.

Generally, everything and phenomena on the Earth cannot exist separately from the time and place. It is important to make a comparison how to express the understanding of time and place in human thought, furthermore investigate carefully the ways of combining the adverbs in Mongolian language with each other and other parts of speech, their structures and forms of meaning.